



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Харгуй ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/02/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112 Цахим хуудас: www.audit.mn
	Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390
	Ахлах аудитор: Н.Туяа Утас: 99799709
	Аудитор: Ц.Нарангэрэл Утас: 99028942

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

1. Аудитын дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
Байгууллагын үйл ажиллагаа	9
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.2.1 Албан шаардлага	12
4.2.2 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
6. Албан шаардлага	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.22 № 272

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
ХАРГУЙ ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Л.БАТ-ОКТЯБРЬ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Харгуй ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хэнтий аймгийн Харгуй ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

E:/DOTOOD AJIL/BX 2022/явсан бичиг/A4 20220322 272

023041716

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

	Үзүүлэлт	2021 оны 01-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	465,611,542.95	27,641,872.03
1.1.2	Дансны авлага	153,469,072.76	983,778,163.59
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	3,698,231.78	19,438,267.52
1.1.4	Бусад авлага	461,643.00	201,728.00
1.1.6	Бараа материал	193,862,554.96	167,656,584.46
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	817,103,045.45	1,198,716,615.60
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,036,445,680.71	2,932,712,070.40
1.2.2	Биет бус хөрөнгө	148,770,000.00	148,770,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,185,215,680.71	3,081,482,070.40
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,002,318,726.16	4,280,198,686.00
2.1.1.1	Дансны өглөг	0.00	59,778,200.00
2.1.1.3	Татварын өр	943,000.00	1,443,890.56
2.1.1.4	НДШ - ийн өглөг	60,900.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	102,727,272.73
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,003,900.00	163,949,363.28
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,003,900.00	163,949,363.28
2.3.1	Өмч: - төрийн	436,426,000.00	436,426,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	171,465,655.46	171,465,655.46
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,375,149,839.44	3,375,149,839.44
2.3.9	Хуримтлагдсан ашиг	18,273,331.26	133,207,827.82
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,001,314,826.16	4,116,249,322.72
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,002,318,726.16	4,280,198,686.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,035,898,841.95	3,266,348,394.54
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,465,545,114.85	2,533,001,036.89
3	Нийт ашиг (алдагдал)	570,353,697.11	733,347,357.65
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	2,934,556.70	0.00
6	Мал аж ахуйн орлого	232,571.78	359,509.45
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	456,768,413.07	574,378,799.67
11	Санхүүгийн зардал	229,660.00	206,420.00
12	Бусад зардал	76,773,766.15	27,441,751.26
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	39,748,986.37	131,679,896.18
19	Орлогын татварын зардал	3,974,898.64	13,167,989.62
20	Татварын дараах ашиг (алдагдал)	35,774,087.73	118,511,906.56
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	35,774,087.73	118,511,906.56
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	35,774,087.73	118,511,906.56
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2020 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	(15,470,756.47)	3,967,570,738.43
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	35,774,087.73	35,774,087.73
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(2,030,000.00)	(2,030,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
{2020} оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	18,273,331.26	18,273,331.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	118,511,906.56	118,511,906.56
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(3,577,410.00)	(3,577,410.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	133,207,827.82	4,116,249,322.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,621,691,044.00	2,885,997,975.50
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,592,233,269.54	2,837,463,836.50
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	29,457,774.46	48,534,139.00
1.2	Мөнгөн зарлага (-)	2,072,963,857.64	3,250,672,236.42
	Ажиллагчдад төлсөн	485,230,284.00	535,595,960.31
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	145,922,487.63	173,518,217.27
	Бараа материал худалдан авахад төлсөн	497,258,429.60	1,094,835,289.91
	Ашиглалтын зардалд төлсөн	35,162,603.38	37,679,872.63
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	551,344,298.54	732,336,147.50
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	188,141,919.88	217,083,779.34
	Даатгалын төлбөрт төлсөн	7,730,640.00	7,493,262.00
	Бусад мөнгөн зарлага	162,173,194.61	452,129,707.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	548,727,186.36	(364,674,260.92)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,934,556.70	0.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	2,934,556.70	0.00
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	85,475,450.00	69,718,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	85,475,450.00	69,718,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(82,540,893.30)	(69,718,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,030,000.00	3,577,410.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	2,030,000.00	3,577,410.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,030,000.00)	(3,577,410.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	464,156,293.06	(437,969,670.92)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,455,249.89	465,611,542.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	465,611,542.95	27,641,872.03

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Харгуй ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналт, хариуцлага, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа, аудитор Ц.Нарангэрэл нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар тус тус хэрэгжүүлсэн.

Харгуй ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 1/19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Харгуй ТӨХК -ийн үндсэн зорилтыг “Монгол улсад авто замын салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, салбарын хуулийн этгээдүүдэд ижил тэгш нөхцөлөөр үйлчлэх, төсвийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлж, өөрийгөө бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авахад дотоод аудит хийгдээгүй тул аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Харгуй ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аудитын код: ХЭА-2022/02/НА-СТА-ТӨҮГ

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,999.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 20.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Байгууллагын үйл ажиллагаа

Харгуй ТӨХК нь улсын чанартай А0501 кодтой Улаанбаатар-Өндөрхаан, А0502 кодтой Өндөрхаан-Чойбалсан, А2001 кодтой Өндөрхаан-Баруун-Урт, А19 кодтой Өндөрхаан-Норовлин-Баян-Уул, А36 кодтой Чойр -Өндөрхаан гэсэн 5 чиглэлийн хатуу хучилттай 372.1 км, хайрган хучилттай 189 км, ердийн хөрстэй 165 км авто зам, 1109.8 у/м төмөр бетон, модон гүүрийг хариуцан, нийт 65 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг :

- Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, гарсан эвдрэл, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- Компани нь замын барилгын үйлдвэрлэл эрхэлж, тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах
- Компани нь авто замын засвар арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэх гэжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 100 хувь эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Харгуй ТӨХК-ийг Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 17-ны 187 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Харгуй ТӨХК нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гэрээнд ордог”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг” заалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага болох Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь компанийн гүйцэтгэх захирлыг томилж, гэрээ байгуулдаг. Гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1 “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх”, 84.4.2 “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, 84.4.3 “компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” гэж заасны дагуу компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг өдөр тутам удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцан ажилладаг.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 65 орон тоотой ажиллаж, 118.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант онд Засгийн газраас халаалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан орон сууц бүхий ажилтнуудад 3,360.0 мянган төгрөгийг түлээ нүүрсний хөнгөлөлтөд давхардуулан олгож, ажилчдын шагналд 5,382.0 мянган төгрөг, шинэ жилийн бэлэг авахад 3,535.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн тайлангийн тодруулга

Харгуй ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	465.6	27.6	(438.0)
БХХО			-
Авлага	157.6	1,003.4	845.8
Урьдчилгаа			-
Бараа материал	193.9	167.7	(26.2)
Үндсэн хөрөнгө	3,036.4	2,932.7	(103.7)
Биет бус хөрөнгө	148.8	148.8	-
Нийт хөрөнгө	4,002.3	4,280.2	277.9
Өр төлбөр	-	-	-
Богино хугацаат өглөг	1.0	164.0	163.0
Урт хугацаат өглөг			-
Эздийн өмч	4,001.3	4,116.2	114.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,002.3	4,280.2	277.9

Аудитын код: ХЭА-2022/02/НА-СТА-ТӨҮГ

Банк дахь харилцах дансанд байгаа 27.6 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаас, Төрийн банк дахь харилцах дансанд 3.6 сая төгрөгийн, Хас банк дахь харилцах дансанд 24.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага 1,003.4 сая төгрөг болж 845.8 сая төгрөгөөр өссөн нь Хэнтий аймгийн Чингис хотын төв замын засварын ажлыг хийж гүйцэтгэж, Хэнтий аймгийн ЗДТГ-аас 850.3 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд татвар, шимтгэлийн авлага 19.4 сая төгрөг, ажиллагсдаас авах авлага 66.7 сая төгрөг, бусад хувь хүнээс 12.3 сая төгрөг, байгууллагаас авлага 905.0 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 167.7 сая төгрөг болж 26.2 сая төгрөгөөр буурсан нь 1,605.8 сая төгрөгийн худалдан авалт хийж, 7.9 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлого авч, 1,653.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,932.7 сая төгрөг болж 103.7 сая төгрөгөөр буурсан нь 224.3 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна. Тайлант онд 177.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, авлагад 57.0 сая төгрөгийн орон сууц орлогоор авсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 164.0 сая төгрөг болж 163.0 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг 59.8 сая төгрөг, орлогын татварын өглөг 1.4 сая төгрөг, урьдчилж орсон орлого 102.7 төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч 114.9 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан ашиг данс тайлант оны 118.5 сая төгрөгийн ашгаар нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Харгуй ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны 632 дугаар тогтоолоор Харгуй ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны борлуулалтын орлогыг 2,160.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,115.2 сая төгрөгөөр, 40.3 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон.

Гүйцэтгэлээр 3,266.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,147.8 сая төгрөгийн зардал гарган, 118.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,266.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,106.3 сая төгрөг буюу 51.2 хувиар давсан нь орон нутгийн чанартай авто замын засварын ажлыг өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан тендерээр авч гүйцэтгэсэнтэй холбоотой.

Нийт зардлын гүйцэтгэл 3,147.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,032.6 сая төгрөг буюу 48.8 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант онд дээрх орон нутгийн чанартай зам засварын ажлыг өөрийн нөөц боломжоор гүйцэтгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу шуурхай ажиллагааны хэсгийн барилгын их засвар, компьютер принтер авахад өөрийн эх үүсвэрээс 69.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 40.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 78.2 сая төгрөгөөр илүү байгаа нь орон нутгийн чанартай зам засварын ажлыг гүйцэтгэсэн нь нөлөөлж байна.

Аудитын код: ХЭА-2022/02/НА-СТА-ТӨҮГ

ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу тайлант онд 2020 оны ногдол ашиг 3.5 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Харгуй ТӨХК-ийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих нийт мэдээлбэл зохих 3,597.0 сая төгрөгийн 182 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК аудит хийж 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг анхаарч үзэхээр шийдвэрлэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

4.2.1 Албан шаардлага

1. Засгийн газраас халаалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан орон сууц бүхий ажилтнуудад 3,360.0 мянган төгрөгийг түлээ нүүрсний хөнгөлөлтөд давхардуулан олгож, ажилчдын шагналд 5,382.0 мянган төгрөг, шинэ жилийн бэлэг авахад 3,535.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын дотоод аудитын ажилтан нь санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолын 4.1. "Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна", 4.1.5. "Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөнд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг тусган гүйцэтгэлийг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдлийг тулгахад дэлгэрэнгүй тайлангаас сэлбэг хэрэгслийн материал 6,080.3 мянга, хангамжийн материал 10.1 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн 383.8 мянга, нийт 6,474.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн гаргасан бараа материалын дэлгэрэнгүй тайланг тулган шалгаж авч байх.

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тулгахад дэлгэрэнгүй тайлангаас компьютер дагалдах хэрэгслийн тайлан 590.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн гаргасан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг тулгаж шалгаж авч байх.

4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акттай тулгахад ажилчдад цалингийн урьдчилгааг өндөр дүнгээр олгож, бүрэн суутгадаггүй үлдэгдэл дүн их байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 104.1. "Цалин хөлсийг сард хоёроос доошгүй удаа тогтсон өдөр олгох бөгөөд олгох өдрийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн дотоод журмыг өөрчилж цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн 50 хувиас хэтрүүлэхгүй, сардаа тооцон суутгах зэргээр тодорхой заалтыг тусгаж, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Харгуй ТӨХК	5	19.3					1	12.3	4	7.0
Дүн		5	19.3					1	12.3	4	7.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Харгуй ТӨХК	0	0								
Дүн		0	0								
Нийт дүн		5	19.3					1	12.3	4	7.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 188/А2370447
ХЭА 2022/02/НА-ЕТА-ТШС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Харгуй ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор орон сууцанд амьдарч байгаа айл өрхийн халаалтын төлбөрийг төрөөс бүрэн хариуцан төлсөн байхад орон сууцанд амьдарч байгаа албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 3,360.0 мянга, ажилчдын шагналд 5,382.0 мянга, шинэ жилийн бэлэг авахад 3,535.0 мянган, нийт 12,277.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмч, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м) -ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харгуй ТӨХК-ийн захирал Л.Бат-Октябрь, ерөнхий санхүүч Д.Идэрбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

